



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 оны 08 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар хар/1433

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

Тогтоол хэрэгжүүлэх асуудлаар
чиглэл өгөх тухай

Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд нийцүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг тогтоох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолыг батлан гаргалаа.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлаар Та бүхэнд дараахь чиглэлийг өгч байна.

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь аймгийн хэмжээнд төрийн удирдлагын манлайлалыг хэрэгжүүлэн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, нутгийн захиргааны боловсон хүчний бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургах, давтан сургах, төрийн албанд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, түүнд судалгаа, шинжилгээ хийх, хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

2. Хууль, эрх зүйн хэлтэс /архивын тасагтай/ нь нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулах, аймгийн Засаг даргаас хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллах, Засаг даргыг хууль зүйн зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, хууль тогтоомжийн системчлэл, сурталчилгаа, эрх зүйн сургалт, иргэдэд хууль тогтоомжийн лавлагаагаар үйлчлэх, төрийн архивын үйл ажиллагааг эрхлэх, байгууллагуудын архивын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэсэн аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус хэлтэс нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, аялал жуулчлал, дэд бүтэц /эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо, шуудан/, хот байгуулалт, архитектур төлөвлөлт, газрын харилцаа, байгаль орчин /байгаль хамгаалах, түүний баялгийг

003541

зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх/, хүнс, хөдөө аж ахуй /малын эрүүл мэнд, үржил селекция, бэлчээр ашиглалт, усан хангамж, газар тариалан/, хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар аймгийн хэмжээнд баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг гүйцэтгэнэ. Өрхийн аж ахуй, жижиг бизнесийг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд энэ хэлтсийн үйл ажиллагааг илүүтэй чиглүүлж ажиллуулахын хамт санхүү, төрийн сангийн болон нийгмийн бодлогын хэлтсүүдтэй үйл ажиллагааг нь нягт уялдуулахад анхаарах нь зүйтэй.

4. *Нийгмийн хөгжлийн хэлтэс* нь аймгийн нийгмийн хөгжлийн стратеги, бодлогыг боловсруулах, төлөвлөх, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд зэрэг хүн ам зүйн чиглэлээр явуулах бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилгүйдэл, ядуурлыг орон нутгийн түвшинд бууруулах бодлогыг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх ажилд онцгой анхаарч ажиллахад энэ хэлтсийн үндсэн үйл ажиллагаа чиглэгдэх ёстой гэж үзэж байгаа болно.

Засаг даргын дэргэдэх нийгмийн чиглэлийн агентлагуудын үйл ажиллагааг бодлогын түвшинд удирдах, зохицуулах чиг үүргийг сайтар хэрэгжүүлэх чиглэлд тус хэлтсийн үйл ажиллагааг чиглүүлж, боловсон хүчнийх нь чадавхийг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

5. *Санхүү, төрийн сангийн хэлтэс* нь аймгийн төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, төрийн сангийн зарлага, санхүүжилтийг гүйцэтгэх, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, татварын орлогын төлөвлөлт, татвар хураалтын ажлын зохион байгуулах, нийгмийн даатгал, хөрөнгө оруулалт, зээлийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, Засаг даргын дэргэдэх агентлагуудын төсөв, санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5. *Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийг* Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулах үйл ажиллагааны үе шат бүрт хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын цар хүрээг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бие даасан хэлтэс болгосон болно.

Энэ хэлтэс нь аймгийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг ерөнхий арга зүйгээр хангах бөгөөд цаашид Засгийн газрын болон Засаг даргын шийдвэрийн биелэлтэд хийх хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудалд үйл ажиллагааг нь илүүтэй чиглүүлж ажиллуулах шаардлагатай гэж үзэж байна.

6. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдуулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд чиг үүрэг, нэрийн хувьд өөрчлөлтүүд орсон болно.

Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллах ажиллагааны албатай/-ыг шинээр байгуулсан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр өмчийг ашиглах, зарцуулах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, орон нутагт зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

Засгийн газрын тогтоол нь нийтээр нэг мөр дагаж мөрдөх шийдвэр тул Засаг даргын Тамгын газрын бүтцийг тогтоолын дагуу зохион байгуулах шаардлагатайг эцэст нь анхааруулж байна.

Монгол Улсын сайд
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

Төрийн үйлчилгээг иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг, идэвхтэй, санаачилгатай, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх, мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, шуурхай хүргэх, гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг аймаг орон нутагтаа татах, төрийн албан хаагчдыг манлайлан ажиллах зорилт дэвшүүлэн, энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд аймгийн удирдлагууд, ЗДТГ-ын хэлтэс, тасаг, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

Нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулах, аймгийн Засаг даргаас хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллах, Засаг даргыг хууль зүйн зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, хууль тогтоомжийн системчлэл, сурталчилгаа, эрх зүйн сургалт, иргэдэд хууль тогтоомжийн лавлагаагаар үйлчлэх, төрийн архивын үйл ажиллагааг эрхлэх, байгууллагуудын архивын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

Аймгийн эдийн засгийн тогтвортой өсөлт болон нийгмийн үйл ажиллагааг бүхий л салбарын хүрээнд хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлж төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажил үйлчилгээг хууль эрх зүйн бүрэн хяналтанд, үр ашигтайгаар хуваарилан зарцуулахад хяналт тавин удирдан ажиллахад оршино.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын “Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, Төлөвлөлтийн хэлтэс” /ХОХБТХ/ нь Хэнтий аймгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хэнтий аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэсэн аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

Төрийн хууль тогтоомжийг орон нутгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, түүнд нийцүүлэн нийгмийн чанартай үйлчилгээг иргэн бүрт үзүүлэх боломжийг олгох замаар хүний хөгжлийг иргэн бүрт үзүүлэх боломжийг олгох замаар хүний хөгжлийг тэгш хангахад оршино.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулах үйл ажиллагааны үе шат бүрт хийгдэх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын цар хүрээг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, зорилготойгоор аймгийн хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг ерөнхий арга зүйгээр хангаж, Засгийн

газрын болон Засаг даргын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаагаа илүү чиглүүлэн ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

ЦЭРГИЙН ШТАБ

Батлан хамгаалах талаар хууль тогтоомжийн бодлого шийдвэр, тэдгээртэй уялдуулан гаргасан Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, гаргасан захирамжийг хэрэгжүүлэх ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, цэргийн мэргэжлийн удирлагаар хангах явдал юм.